

## МОБИЛИТИ ТӨСЛИЙН САНАЛ ГАРГАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Миний бие ..... овогтой ..... (РД ..... ) мобилити төслийн санал гаргагчийн хувьд дараах мэдэгдлийг гаргаж байна.

1. «.....» нэртэй мобилити төслийн саналд тусгагдсан бүх мэдээлэл, түүнд хавсаргасан баримт бичиг нь бүрэн бөгөөд үнэн зөв болохыг үүгээр мэдэгдэж байна.

**2. Мобилити төслийн саналын сонгон шалгаруулалтын хүрээнд:**

- Урд өмнө төслийн санал гаргасан/ гаргаагүй (сонгож зурах)

- 2026 оны ..... сарын .....-ны өдөр төслийн санал гаргасан гаргасан болно.

3. Мобилити төслийн зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулах аливаа эрх зүйн болон бусад үүрэг надад байхгүй болно.

4. Мобилити төслийн саналын сонгон шалгаруулалтын үнэлгээний ажиллагаанд оролцож буй эрх бүхий этгээдүүд миний өргөдлийн материалтай бүрэн эхээр нь танилцахыг зөвшөөрч байна.

5. Мобилити төслийн санал дэмжигдэж, санхүүжилт авсан тохиолдолд төслийн саналд тусгасан бүх үүрэг, амлалтыг бүрэн хэрэгжүүлэхээ үүгээр хүлээн зөвшөөрч байна.

6. Мобилити төслийн санал гаргагчийн хувьд миний хувийн мэдээллийг боловсруулах эрх зүйн үндэслэл нь хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бөгөөд мэдээлэл боловсруулах зорилго нь энэхүү сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулахад оршиж байгааг ойлгож байна.

7. Мобилити төслийн санал, түүнд агуулагдах судалгааны үр дүн, бүтээл нь зөвхөн миний болон хамтран зохиогчдын оюуны бүтээл мөн болно.

8. Мобилити төслийн санал боловсруулах явцад хиймэл оюун ухаан ашигласан, ашиглаагүй болно. (сонгож зурах) Ашигласан бол ил тод байдлын зарчмыг баримтлан дараах мэдээллийг бөглөнө.

| Ашигласан үйл ажиллагаа | Ашигласан программ<br>(хувилбар) | Ашигласан зорилго,<br>тайлбар |
|-------------------------|----------------------------------|-------------------------------|
| Санал боловсруулах      |                                  |                               |
| Төлөвлөгөө боловсруулах |                                  |                               |

|                                    |  |  |
|------------------------------------|--|--|
| Ном зүйн судалгаа хийх             |  |  |
| Өгөгдөл боловсруулах / Код бичих   |  |  |
| Хэл найруулга засварлах / Орчуулах |  |  |
| Дүрслэл, зураг боловсруулах        |  |  |

**Тайлбар:** Хиймэл оюун ухааныг зөвхөн зөв бичгийн дүрэм шалгах зорилгоор ашигласан бол дээрх хүснэгтийг бөглөх шаардлагагүй.

**Түүнчлэн дараах мэдэгдлийг гаргаж байна.**

- Өргөдлийн агуулгын үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- Хиймэл оюун ухааны тусламжтай боловсруулсан агуулгын үнэн зөв, бүрэн бүтэн байдал болон эх сурвалжийн бодит байдлыг шалгаж баталгаажуулсан.
- Хуурамч мэдээлэл (hallucination) болон алгоритмын гажуудал (bias)-ыг илрүүлэх зорилгоор агуулгыг шүүмжлэлтэйгээр хянасан.
- Ашигласан бүх эшлэл, ном зүй, эх сурвалж нь бодит бөгөөд шалгах боломжтой.
- Хиймэл оюун ухааны системд тухайн хүний зөвшөөрөлгүйгээр хувийн мэдээлэл, нийтлэгдээгүй судалгааны мэдээлэл болон оюуны өмчид хамаарах мэдээлэл оруулаагүй.
- Ашигласан хиймэл оюун ухааны хэрэгслийн хувийн мэдээлэл боловсруулах бодлоготой танилцсан бөгөөд тухайн систем нь мэдээлэл хамгаалах шаардлагыг хангаж, мэдээллийг загвар сургах зориулалтаар ашигладаггүй болохыг нягталсан.
- Хиймэл оюун ухааны тусламжтай боловсруулсан материалыг ашиглах нь гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй бөгөөд хиймэл оюун ухаанаар боловсруулсан хэсгийг өргөдөл, тайлан, нийтлэлд зохих журмын дагуу тэмдэглэсэн.

Огноо: 2026 оны ..... сарын .....-ны өдөр

Төслийн удирдагч: .....

Нэр: .....

Гарын үсэг: .....